**МОНГОЛ УЛСЫН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН**
**ТУШААЛ**

2019 оны 11 сарын 29 өдөр Дугаар А/526 Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах,
зардал гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9, 8.1.23 дах заалт, 25 дугаар зүйлийн 25.12 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 5.1.3, 6.4.1, 14.2.3, 14.2.5 дах заалт, Эрүүл мэндийн сайдын "Журам шинэчлэн батлах тухай" 2014 оны 119 дүгээр тушаалаар баталсан "Эрүүл мэндийн ажилтанг гадаад оронд мэргэжлийн сургалтад хамруулах журам"-ын 1.5 дах заалт, Сангийн сайдын "Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" 2011 оны А/188 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн яамны харъяа 17 байгууллага, 21 аймгийн удирдах түвшний менежрүүдийг чадавхижуулах сургалтыг Бүгд Найрамдах Солонгос Улсад зохион байгуулсугай.

2. Удирдах ажилтнуудын гадаад сургалтыг хариуцлагатай зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирал /Б.Нарантуяа/-д даалгасугай.

3. Гадаад сургалтад шаардагдах зардлыг энэ онд батлагдсан төгсөлтийн дараах сургалтын зардлаас гаргахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирал /Б.Нарантуяа/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Я.Амаржаргал/-д даалгасугай.

САЙД Д.САРАНГЭРЭЛ